

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 27 өдөр

Дугаар ТУЗ/20/04

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 67.5, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Бодь даатгал ХК-ийн Дүрмийн 6.3, 6.7 дугаар зүйлийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 07 сарын 27-ны өдрийн ээлжит бус хурлаас ТОГТООХ НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал /цаашид “Хурал/ гэх/-ыг 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр 11:00 цагт Улаанбаатар, Монгол Улс, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 14201, Novotel зочид буудал 4 давхарын хурлын танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2020 оны 07 сарын 29-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2020 оны 07 сарын 31-ний өдрийн дотор нийгэд зарласугай. Хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан хоёр ба түүнээс дээш удаа 2020 оны 07 сарын 31-ний өдрийн дотор мэдээлсүгэй.
4. Мэдээллийн давталтыг 2020 оны 08 сарын 17-ны өдөр хүртэлх хугацаанд хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан дахин зарласугай.
5. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 08 сарын 17-ны өдрөөр тогтоосугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2020 оны 08 сарын 03-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
7. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга: Гүйцэтгэх захирал Б.Золбаяр,

Гишүүд: Санхүү, эрсдэлийн удирдлагын газрын захирал Б.Билгүүн,
ТУЗ-н Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг, Маркетингийн ахлах менежер Г.Нарантуяа, маркетингийн менежер Л.Отгонцэцэг, Аудит Ш.Бэжид, Хуульч Г.Төгөлдөр, Хуульч Б.Анхбаяр



8. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
9. Хурлын дэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
10. Хурлын танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
11. Хурлын саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
12. Хурлын материалыг 2020 оны 08 сарын 03-ны өдөр брокер, диллерын компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдэд Хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
13. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Би Ди Сек ҮЦК ХХК-ийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, төв байр хаягаар дамжуулан авах ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2020 оны 09 сарын 07 –ний өдрийн 15:00 цаг байна.
14. Хурлын даргаар Бодь даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Болдхуягийг томилсугай.
15. Хурлын тооллогийн комиссын даргаар Санхүү, эрсдэлийн удирдлагын газрын захирал Б.Билгүүн, гишүүд: Ерөнхий нягтлан бодогч Э.Энхцэцэг, нягтлан Б.Баяр, Б.Цэндхүү болон Би Ди Сек ҮЦК ХХК-ийн ажилтан Э.Эрхэмзаяа нарыг ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
16. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Хурлын дарга Л.Болдхуяг болон Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Золбаяр нарт даалгасугай.
17. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Батчимэг-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ